Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тооттушаалын
7 дугаар хавсралт

*Төлөвлөгөөг үнэлсэн:*

***Төсвийн шууд захирагч.***

Завхан аймгийн Нийгмийн даатгалын
газрын дарга ...............................(С.НЯМЖАВ)

............................

***Нэгжийн дарга.***

*Тайлагнасан:*

Захиргаа хяналтын
хэлтсийн дарга ...........................................(А.МЯДАГМАА)

*2025.06.10*

VI/19.

## ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ***Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.*** | | | | | | | |
| ***Зорилт 1:*** *"Нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан (актуар) тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр байгуулсан олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 1.1 | Ажил олгогч, иргэд, даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, үр дүнг хагас жил тутам Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх; /1.5/ | - | 2 удаагийн сэтгэл ханамжийн судалгаа хийгдсэн байна. | - | Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн сэтгэл ханамжийг 1-5 оноогоор дүгнэж, судалгааны үр дүнг албан бичгээр 6 дугаар сарын 10, 12 сарын 10-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын ерөнхий газар хүргүүлсэн байна. | | |
| ***Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| ***Зорилт 3:*** *"Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 3.1. | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангаж, байгууллагын цахим хуудаст болон мэдээллийн самбарт хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, хяналт тавих; /3.1/ | - | - Мэдээлэл байршуулалтыг 100 хувьд хүргэнэ. | Байгууллагын цахим хуудсанд мэдээлэл байршуулалт 2024 оны жилийн эцсийн байдлаар 100 хувийн гүйцэтгэлтэй байна. | Байгууллагын мэдээллийг үнэн зөв, бодитой мэдээлж мэдээллийн ил тод, нээлттэй байдал хангагдан иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна. | Газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/20 дугаартай тушаалаар мэдээлэл байршуулах болон хяналт тавих эрх бүхий албан тушаалтныг томилсон.<br>2025 оны эхний хагас жилийн байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлыг "shilen.gov.mn"-д хуульд заасан хугацаанд байршуулсан. | |
| | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг | - | - Сар бүрийн хугацаанд | Шилэн дансны хөтлөлтийн 2024 оны | Нийгмийн даатгалын байгууллагын санхүү үйл | 2025 оны эхний хагас жилийн байдлаар шилэн дансны цахим | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2. | хангаж, шилэн дансны цахим хуудаст Нийгмийн даатгалын сан, байгууллагын санхүү үйл ажиллагааны мэдээллийг хугацаанд үнэн зөв, бодитой бүрэн мэдээлж, мэдээлэл байршуултад хяналт тавих; | | байршуулсан мэдээлэл 100 хувь байна.<br>- Шилэн дансны хөтлөлтийн тайлан /4/-г байгууллагын цахим хуудаст Улирал бүрийн дараа сарын 15-ны өдрийн дотор мэдээлсэн байна. | нэгдсэн тайлангаар мэдээлэл байршуулалт 100 хувьтай байна. | ажиллагаа болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд нь үнэн зөв мэдээлж, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна. | хуудсанд "Шилэн дансны хууль" болон "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын дагуу тайлант хугацаанд тусгай зориулалтын сангийн мэдээллийг 68 удаа мэдээлэхээс хугацаандаа 68, газрын үйл ажиллагааны зарцуулалтын мэдээллийг 73 удаа мэдээлэхээс хугацаандаа мэдээлсэн 73 байна. Хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй ба бүрэн мэдээлсэн. | |
| ***Зорилт 3.1:** "Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах"* **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:** | | | | | | | |
| 3.1.1. | Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг газрын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллагад болон газрын үйл ажиллагаа, сангийн зарцуулалтад хяналт шалгалт хийж илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажиллах, | - | - Шалгасан аж ахуйн нэгж, байгууллагын тоо, хамрагдалтын хувь,<br>- Шалгалтад хамрагдсан нийгмийн даатгалын сангийн тоо, мэдээлэл,<br>Илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын хувь. | 32 ажил олгогчийг шалгаж 39 даатгуулагчтай холбоотой 6133,8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу төлсөн зөрчил илэрч Улсын байцаагчийн акт тогтоон 4293,6 мянган төгрөгийг барагдуулан актын биелэлт 80 хувьтай байна. | Шалгалтын үр дүнг тухай бүрт тооцон газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гарган, актын барагдуулалтын мэдээ, тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлж ажилласан байна. | Тус газарт бүртгэлтэй ажил олгогчийн 30 хувийг хамруулан шалгахаар удирдамжийг батлуулсан. Удирдамжийн дагуу шалгалтыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд шалгалтын хугацаа 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдөр хүртэл явагдана.<br><br>2025 оны эхний хагас жилийн байдлаар 7 ажил олгогчийн 11 даатгуулагчтай холбоотой хугацаандаа төлөгдөөгүй 3,408.5 мянган төгрөгийн шимтгэл болон түүнд ногдох алдангийг "Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзсан материал" хүлээн авч шийдвэрийг Прокурорын байгууллагаар хянуулан хугацаандаа төлөгдөөгүй шимтгэлийг нөхөн төлүүлсэн.<br>"Зөрчлийн тухай хууль"-ийн 10 дугаар зүйлийн 10.17.4 дэх заалтын дагуу 4 ажил олгогчид 1,000.0 мянган төгрөгийн торгууль ногдуулан хялбаршуулсан журмаар шийдвэрлэн төлбөрийг бүрэн барагдуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт хангаж ажиллаж байна.<br>Аймгийн прокурорт сар бүр мэдээгээ гарган хүргүүлсэн.<br><br>Нийт 18 ажил олгогчийг шалгаж 22 даатгуулагчтай холбоотой 3,796.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу төлсөн зөрчил илэрч Улсын байцаагчийн акт тогтоон 3,796.5 мянган төгрөгийг барагдуулан актын биелэлт 100 хувьтай байна. | |
| 3.1.2. | Их, дээд, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах; | - | Их, дээд, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг шалгасан байна. | - | Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийн дагуу шийдвэрлэх, хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна. | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа гурван их дээд сургууль, коллеж байгаа бөгөөд 2 ажил олгогчийн 2020-2024 оны санхүүгийн баримтыг бүрэн шалгаж дууссан.<br>Шалгалтаар Хөгжим бүжгийн коллеж нь 2024 онд 4 даатгуулагчтай холбоотой хүүхдээ асрах чөлөөтэй байгаа хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний хэмжээнээс ажил олгогчийн төлөх хувь хэмжээгээр тайлагнаагүй орхигдуулсан зөрчил илэрсэн. Гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзах хэрэг үүсгэн прокурорын байгууллагаар хянуулахаар хүргүүлэн ажилласан.<br>Мөн тус ажил олгогч нь 9 даатгуулагчтай холбоотой төрлийн кодыг буруу тайлагнасан ба шалгалтын явцад холбогдох журамд заасны дагуу залруулах арга хэмжээ авч ажилласан.<br><br>НДЕГ-ын ДАМГ-ын даргын 2025.05.21-ны өдрийн 02/1270 тоот албан бичгийн дагуу хийгдэж буй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хяналт шалгалтын ажлыг 10 дугаар сард шалгаж дуусгахаар түр зогсоосон. | |
| 3.1.3. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах; | - | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, байгууллагуудыг шалгасан байна. | - | Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийн дагуу шийдвэрлэх, хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна. | Хугацаа болоогүй. | |
| 3.1.4. | Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж үр дүнг тооцох, тайланг заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх; | - | -Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь<br>-Илрүүлсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах,<br>-Шалгалтын тайланг хугацаанд Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн байна. | - | Ажилгүйдлийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг шалгаж, үр дүнг тооцож, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажилласан байна. | Тус газрын ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалтыг гүйцэтгэн хугацаанд биелэлтийг хүргүүлэн ажилласан.<br><br>Шалгалтаар 54 даатгуулагчтай холбоотой зөрчил илэрснээс ажилгүйдлийн тэтгэмжийг 26 даатгуулагчид 16,525.3 мянган төгрөг илүү, 8 даатгуулагчид 7,154.7 мянган төгрөгийг дутуу олгосон байна.<br><br>Нийт 23,680.0 мянган төгрөгийн төлбөр зөрчилд Улсын байцаагчийн акт тогтоосон.<br><br>Мөн ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа албан журмаар даатгуулагчаар шимтгэл төлж ажилласан 18 даатгуулагчийн ажилд орсон тушаал шийдвэрийг авч зөрчлийг арилгуулах тухай албан бичгийг Тэтгэвэр тэтгэмжийн хэлтэст хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.5. | Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нэр бүхий 351 объектод төлөвлөгөөт шалгалт хийх, мэдээ тайланг нэгтгэх; | - | Эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах,<br>-Удирдамжийн хугацаанд мэдээ тайланг нэгтгэж, тайланг Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн байна. | 2024 онд 15 объектод хяналт шалгалт хийж, 95 зөрчил илрүүлж, 4 албан шаардлага хүргүүлж, гүйцэтгэл 97.8 хувьтай ажилласан. | Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | 2025 оны эхний хагас жилийн байдлаар их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагаас 19 байгууллага шалгаснаас 73 зөрчил илэрч 50 хувийг арилгуулсан байна. Дээрх илэрсэн зөрчлийг ангилан үзэхэд:<br>-Ус хангамж, сувагжилт хог хаягдлыг хуримтлуулах, түгээх, зайлуулах, боловсрулах, ариутгах чиглэлээр 2 объект хамрагдаж эрсдэлийн түвшин бага, хууль сахин мөрдөлт 91 хувьтай байна.<br><br>-Цахилгаан эрчим хүч, дулаан үйлдвэрлэх, түгээх дамжуулах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 3 ажил олгогчийн эрсдлийн түвшин бага, хууль сахин мөрдөлтийн түвшин 88.8 байна.<br><br>-Барилгын угсралт, барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр урьдчилан сэргийлэх шалгалт төлөвлөгөөт 1, төвөллөгөөт бус 13 объетод хийсэн ба гүйцэтгэлийн шалгалтаар эрсдлийн түвшин тооцно. | |
| 3.1.6. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээ, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал тутамд гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх, | - | - Хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын хувь,<br>- НДЕГ-т хүргүүлсэн тайлан, мэдээний тоо, | Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээг НДЕГ-т хүргүүлж ажилласан. | Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож, тайланг улирал тутамд гарган Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлж ажилласан байна. | НДЕГ-ын даргын 2023 онд баталсан удирдамжийн дагуу 2017-2022 оныг дуусталх хугацааны тус газрын сангийн болон хэлтсийн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхэд үндэслэлгүй баримт бичиг бүрдүүлэн шуухийн шийдвэр гаргуулж тэтгэвэр тогтоолгон авсан 46 иргэнтэй холбоотой 507,578,0 мянган төгрөгийн, нийгмийн даатгалын байцаагчийн алдааны улмаас шалтгаалан 16 иргэнтэй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбоотой 23,707.8 мянган төгрөгийн, нийт 531,286.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.НДЕГ-ын даргын 2023 оны А/69 дүгээр тушаал " Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай"-ын дагуу 7 арга хэмжээ 27 ажил үйлчилгээ бүхий төлөвлөгөө хэлтсийн даргаар батлуулан ажиллаж байна. Төлбөр зөрчлийг барагдуулах Улсын байцаагчийн үйлдсэн төлбөр зөрчлийн актаас 351,757.9 мянган төгрөгийг барагдуулан ажиллаж байна.Актын биелэлт 66,2 хувьтай байна.<br><br>НДЕГ-ын даргын 2024 онд баталсан удирдамжийн дагуу хийгдсэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар 2 даатгуулагчтай холбоотой 38,970.4 мянган төгрөгийн төлбөр зөрчил илэрч Улсын байцаагчийн акт тогтоосон. Актын биелэлт 0.00 хувьтай байна.<br><br>Аймгийн Санхүүгийн хяналт,дотоод аудитын албанаас 2023 онд тус газрын 2020-2021 оныг дуусталх хугацааны тус газрын сангийн болон хэлтсийн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхэд 3,361.0 мянган төгрөгийн зөрчил илэрч Улсын байцаагчийн акт тогтоож 3,160.0 төгрөгийг барагдуулсан Актын биелэлт 94,0 хувьтай байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Дотоодын хяналт шалгалтаар 49,313.6 мянган төгрөгийн төлбөрөөс 12,437.9 мянган төгрөгийг барагдуулан ажиллаж байна. Актын биелэлт 25,2 хувьтай байна.<br>( 2025 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар) | |
| 3.1.7. | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулж, заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх; | - | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлэх, төлбөр, зөрлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах, үр дүнг тооцож ажиллах, | Дотоодын хяналт, шалгалтын тайлан, мэдээг хагас, бүтэн жилээр гаргуулж, нэгтгэн төлбөр, зөрлийн барагдуулалтад хяналт тавьж ажилласан. | Шалгалтын үр дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | 2025 оны эхний хагас жилийн байдлаар НДЕГ-ын төлөвлөгөөт хяналт шалгалтаар 570,257.2 мянган төгрөгийн зөрчил илэрч Улсын байцаагчийн акт тогтоогдсоноос 351,757.9 мянган төгрөгийг барагдуулан ажиллаж байна. Актын биелэлт 61,6 хувьтай байна.<br><br>Дотоодын хяналт шалгалтаар 49,313.6 мянган төгрөгийн төлбөрөөс 12,437.9 мянган төгрөгийг барагдуулан ажиллаж байна. Актын биелэлт 25,2 хувьтай байна.<br>( 2025 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар).<br><br>НДЕГазрын ХШГазарт хяналт шалгалтын эхний хагас жилийн тайланд илэрсэн төлбөр зөрчлийг бүрэн тусган тайланг хугацаанд нь хүргүүлсэн. | |
| **Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.** | | | | | | | |
| ***Зорилт 4:*** *“Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.1. | Нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, шийдвэр, тайлан, биелэлтийг хугацаанд нь | | - 06 дугаар сарын 10, 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна. | 2024 онд тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, биелэлтийг нэгтгэн авч, дүгнэхэд нийт | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангагдсан байна. | Засгийн газрын тогтоол-1, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын тушаал -2, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын албан даалгавар-1, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүргүүлэх; | | -Арга хэмжээний хэрэгжилтийн үр дүн | салбарын хэмжээнд хэрэгжилт 89,4%-тай хэрэгжсэн байна. | | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал-23 тушаал ирсэн бөгөөд тухай бүр хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | |
| 4.2. | Байгууллага, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах; | | -Улирал бүрийн 20-ны өдрийн дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлнэ.<br>-Өргөдөл шийдвэрлэлтийг 100% хугацаанд нь, үнэн зөв, бодит үр дүнтэй шийдвэрлэсэн байна. | Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийн түвшин салбарын хэмжээнд 2024 онд 100%-тай хэрэгжсэн байна. | Иргэд, даатгуулагч, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, шийдвэрлэлтийн мэдээг үнэн зөв гаргаж, хүргүүлсэн байна. | 2025 оны эхний хагас жилийн тус газарт байдлаар иргэд, даатгуулагчдаас 86 өргөдөл гомдол хүлээн авснаас 76 шийдвэрлэж, 10 өргөдөл шийдвэрлэх хуулийн хугацаанд байгаа талаар мэдээ тайланг холбогдох журмын дагуу гаргасан. | |
| 4.3. | Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, сул орон тоог хууль тогтоомжийн дагуу нөхөх; | | Төрийн албаны тухай хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргасан байна. | Хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангаж ажилласан. | Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргах, Нийгмийн даатгалын ерөнхий газарт орон тооны мэдээг сар бүр тайлагнасан байна. | 2025 оны эхний хагас жилийн байдлаар тус газарт гарсан 5 сул орон тооны захиалгыг аймгийн төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж ажилласан бөгөөд Тэтгэмжийн тогтоолт олголтын байцаагч, мэргэжилтэн, Сантмаргаз сумын байцаагч, мэргэжилтний сул орон тоо зохих журмын дагуу нөхөгдсөн.<br>Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтсийн дарга, Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, Яруу сумын Нийгмийн даатгалын байцаагч гэсэн сул орон тоо нөхөгдөөгүй байна.<br><br>Төрийн албаны тангараг өргөх 2 албан хаагчийн судалгааг хүргүүлж, тангаргын хуудсыг авч тангараг өргүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.<br><br>Батлагдсан орон тооны гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүрийн 05 дотор гаргаж НДЕГ-т хүргүүлэн ажилладаг.Мөн хүний нөөцтэй холбоотой 9 удаагийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | судалгаар гаргаж холбогдох газар хүргүүлэн ажилласан байна. | |
| 4.4. | Нийгмийн даатгалын газрын ажилтан, албан хаагчдын Нийгмийн даатгалын улсын байцаагч, мэргэшлийн зэргийн нэмэгдэл болон бусад холбогдох судалгаар гаргаж хууль тогтоомжийн дагуу холбогдох баримт бичгийг хүргүүлэх; | | Холбогдох судалгаар гаргаж хугацаанд нь хүргүүлсэн байна. | - | Судалгаар үнэн зөв гаргаж холбогдох баримтыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн байна. | Төрийн захиргааны зэрэг дэв ахиулах болон шинээр авах 15, мэргэшлийн зэрэг ахиулах болон шинээр авах 15 албан хаагчийн материалыг журмын дагуу бүрдүүлж холбогдох дээд газарт хүргүүлэн шийдвэрлүүлж ажилласан. | |
| 4.5. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас батлагдсан "Нийгмийн баталгаар хангах хөтөлбөр"-ийн дагуу дунд хугацааны дэд төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах; | | Хэрэгжилтийг 2025 оны 06 дугаар сарын 10, 12 дугаар сарын 10-ны дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна. | Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгаар хангах дунд хугацааны хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлсэн. | Нийгмийн баталгаар хангах хөтөлбөрийг дунд хугацааны дэд төлөвлөгөөг баталж, газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгаар хангасан байна. | Ажилтан албан хаагчдын нийгмийн баталгаар хангах 11 заалт бүхий төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:<br>- Аймгийн засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт 1 албан хаагч шалгаран "Орон сууцны хөнгөлөлт"-д хамрагдан 20.0 сая төгрөгийн хөнгөлөлтөнд хамрагдсан.<br>- Албан хаагчдад хоол унааны мөнгийг зохих журмын дагуу сар бүр тооцон олгож байна.<br>- 15 албан хаагчийн зэрэг дэв ахиулах, шинээр авах саналыг хүргүүлж, шийдвэрлүүлсэн.<br>- Газрын 1, 2 дугаар давхрын үйлчилгээний зааланд албан хаагчид цайны булан байгуулсан.<br>- Яамны болон Ерөнхий газрын шагналд 3 албан хаагчийг тодорхойлж шийдвэрлүүлсэн.<br>Монголын үндэсний уламжлалт цагаан сарын баяраар газрын харъяа 15 ахмад настанд 750,0 мянган төгрөгийн хүндэтгэл үзүүлэсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.6. | 2024 онд гарсан хууль эрх зүйн зөрчил, шүүхээр шийдвэрлүүлсэн маргаан, хэлэлцэгдэж байгаа хэрэг маргааны судалгааг хүргүүлэх; /4.7/ | | - Судалгааг тухай бүр нь хүргүүлсэн байна. | - | Судалгааг үнэн зөв гаргаж, холбогдох баримт, мэдээллийг Захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтэст хүргүүлнэ. | Байхгүй. | |
| 4.7. | Дээд байгууллагаас өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр нь хүргүүлж ажиллах; /4.8/ | | -Хугацаанд нь хүргүүлэх,<br>-Баримтын чанар, үзүүлэлт тодорхой байна. | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд Нийгмийн даатгалын ерөнхий газраас өгсөн үүрэг даалгавар, албан бичиг, шийдвэрийг цаг хугацаанд нь ирүүлсэн байдал 75%-тай байв. | Үүрэг даалгавар, албан бичиг, шийдвэрийг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ. | НДЕГазраас 39 хугацаатай бичгийн үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр нь хүргүүлж ажилласан. | |
| ***Зорилт 4.1:*** *"Нийгмийн даатгалын байгууллагыг мэргэшсэн хүний нөөцөөр бүрдүүлэх, байцаагч, ажилтныг чадавхжуулах, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургалтыг системтэй, мэргэжлийн түвшинд байнга тасралтгүй явуулах, нөгөө талаар ажил олгогч, даатгуулагчдад нийгмийн даатгалын талаарх хууль эрх зүйн мэдлэг олгох хичээл сургалтыг нэгдсэн хөтөлбөрийн дагуу зохион байгуулах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.1.1. | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг зохион байгуулах; | | -Авлигаас урьдчилан сэргийлэх 2 удаагийн сургалт зохион байгуулах,<br>-Нийт албан хаагчдыг 100% хамруулсан байна. | Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. | Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны 2 бүлэгтэй 15 заалт бүхий төлөвлөгөө батлан хэрэгжүүлэн ажиллаж байна.<br><br>Авлигатай тэмцэх газар болон Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 1 удаагийн сургалтанд нийт байцаагч ажилтнуудыг хамруулсан. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө зөвлөмжийг тухай нь бүр өгч ажиллаж байна. | |
| 4.1.2. | Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ажилтнуудыг сургаж хөгжүүлэх; | | - Сургалтыг өмнөх оноос 10-аас доошгүй хувиар зохион байгуулах,<br>-Албан хаагчдыг 100% хамруулсан байна. | Албан хаагчдыг чадавхижуулах, ур чадварыг дээшлүүлэх 34 удаагийн сургалтад 50 албан хаагчийг танхим болон цахимаар хамруулав. | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх цахим болон танхимын сургалтыг зохион байгуулсан байна. | Газрын ажилтнуудын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр НДЕГ-аас 8, дотоодын 3, гадны байгууллагын 8 удаагийн сургалт зохион байгуулж нийт байцаагч ажилтан бүрэн хамрагдаж мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн байна.<br>Шинээр болон шилжин томилогдсон төрийн захиргааны 6 төрийн үйлчилгээний 1 албан хаагчид шинэ ажилтны сургалт болон байгууллагын хөдөлмөрийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дотоод журмыг танилцуулан, Төрийн үйлчилгээний 1 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна. | |
| 4.1.3. | Ажил олгогч, даатгуулагч, иргэдийн нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах; | | -Даатгуулагчид чиглэсэн сургалтыг өмнөх оноос 10-аас доошгүй хувиар зохион байгуулах,<br>- 30-аас доошгүй аж ахуйн нэгжийг хамруулах,<br>-Иргэд, даатгуулагчдын 10-иас доошгүй хувийг хамруулсан байна. | Ажил олгогч, иргэд, даатгуулагчид чиглэсэн 152 удаагийн сургалтад 89 аж ахуйн нэгжийн 8471 иргэд, даатгуулагч, ажил олгогчийг хамруулав. | Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн ойлголтыг дээшлүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулж, иргэд даатгуулагчийг өргөнөөр хамруулсан байна. | Ажил олгогч, иргэд, даатгуулагчид чиглэсэн 94 удаагийн сургалтад 150 аж ахуйн нэгжийн 5448 иргэд, даатгуулагч, ажил олгогчийг хамруулав. | |
| ***Зорилт 4.2:** “Нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх, сайжруулах, цахим, нэг цэгийн болон явуулын хэлбэрээр нийгмийн даатгалын үйлчилгээг явуулах, олон нийт, харилцагч болон харьяа байгууллагуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.2.1. | Нийгмийн даатгалын байгууллагад хэрэгжүүлж буй ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах; | - | Шинээр 1-ээс доошгүй шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулна. | Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний болон ажлын байрны стандартыг мөрдөж ажилласан. | Ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах чиглэлээр улирал бүр 1-ээс доошгүй шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулж, үр дүнд хүрсэн байна. | Ажлын байр, үйлчилгээний стандартыг мөрдөн ажиллаж байна.<br>1.Газрын гаднах хаяг, байцаагч ажилтнуудын өрөөний хаяг зэргийг НДЕГ аас ирүүлсэн стандартын дагуу хийж байршуулсан.<br><br>2.Газрын байцаагч ажилтнууд ажлын байранд цагаан буюу цэнхэр өнгийн цамц, хар, хар хөх өнгийн юбка өмдөөр жигдрэн иргэдэд үйлчилгээ үзүүлж байна<br>Мөн хар ногоон, цагаан өнгийн поло подволкоор жигдэрсэн. | |
| 4.2.2. | Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах; | - | Дуудлага алдалт 10% ба 15%-аас хэтрүүлэхгүй ажилласан байна | 2024 онд 169 дуудлага ирсэнээс 151 дуудлагыг авч дуудлага алдалт 10.65 хувьтай байна. | Иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээллийг шуурхай өгч, ажилласан байна. | 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 320 дуудлага ирсэнээс 310 дуудлагыг авч дуудлага алдалт 3.1 хувьтай байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.3. | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангах; | - | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгааг<br>-"Рийл" улиралд 3-аас доошгүй удаа;<br>-"Постер" сард 3-аас доошгүй удаа;<br>-"Видео контент" улиралд 1 удаа;<br>-Хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан мэдээ мэдээлэл өгөх, сард 2-оос доошгүй удаа; | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлаж, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангаж ажилласан. | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, үйл ажиллагааг сурталчилсан сурталчилгаа бэлтгэж түгээх. Нийгмийн даатгалын ерөнхий газрын пэйж хуудсаар нийтэлсэн мэдээ мэдээллийг тогтмол түгээж ажилласан байна. | Тайлант хугацаанд 4 удаагийн шууд дамжуулалт, 27 удаагийн постер мэдээлэл, 1 удаагийн видео контентыг хийн нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд даатгуулагчдад хүргэж ажилласан.<br>Тус газрын фейсбүүк пэйж сошиал хуудас нь 4,033 дагагчтай бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дагагч 1,000 мянган дагагчаар нэмэгдсэн байна. Мөн инстаграм хуудас нээн хөтөлж байна.<br><br>Zavhan.ndaatgal.mn веб хуудас болон Завхан аймгийн Нийгмийн даатгалын газар хуудсанд нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн талаар нийт 105 мэдээлэл байршуулан түгээж 27,509 иргэнд хүрсэн.<br><br>Иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, харилцагч талуудад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах, зөвлөгөө, мэдээллийг тогтмол ойлгомжтой байдлаар хүргэх зорилгоор гарын авлага, сурталчилгааны хуудсыг олон нийтийн сүлжээ, цахим хуудсаар түгээж ажиллав. | |
| ***Зорилт 4.5:*** *"Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.5.1. | Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах; /4.5.3/ | | Програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангах | | Програм хангамжуудын эрхийн тохиргоог зөв хийх, байцаагч ажилтнууд програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангаж ажилласан байна. | Програм хангамжуудад 12 удаагийн эрхийн тохиргоог хийж байцаагч ажилтнууд програм хангамжуудыг зөв зохистой ашиглах, аюулгүй байдлыг хангах чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна. | |
| | | | МТТ-өөс хүргүүлсэн албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх, бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байх | | МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн ирүүлсэн байна. | 2025 оны эхний хагас жилийн байдлаар МТТөвөөс ирүүлсэн 4 удаагийн судалгааг хугацаанд хүргүүлсэн. | |
| **Зорилт 4.6:** "Даатгуулагчийг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил"-ийн хүрээнд **/Шинээр санаачлан хийх ажил/** | | | | | | | |
| 4.6.1 | Нийгмийн даатгалын явуулын үйлчилгээг сум баг бүрт үзүүлж багийн засаг дарга нарын нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлж ndaatgal апп-ыг эзэмшүүлж цаашид багийн засаг даргаар дамжуулан иргэдийг нийгмийн даатгалын цахим үйлчилгээ авах сургалт хийх боломж олгох | | 24 сумын иргэн бүрт хүрч үйлчилсэн байна. Нийгмийн даатгалын салбарын хууль,журам,дүрмийн талаар нэгдсэн ойлголттой болж хэрэглээний апп бүрэн эзэмшиж сурсан байна. | - | 24 сумын иргэн бүрт хүрч үйлчилсэн байна. Нийгмийн даатгалын салбарын хууль, журам, дүрмийн талаар нэгдсэн ойлголттой болж хэрэглээний апп бүрэн эзэмшиж сурсан байна. | 20 сумын 58 багийн 4158 иргэд даатгуулагчдад явуулын үйлчилгээ үзүүлж нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан. | |
| 4.6.2 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг нийгмийн даатгалын байгууллагаас үйлчилгээ авахад хурдан шуурхай ойлгомжтой хүргэх нөхцлийг бүрдүүлж газрын нэг ажилтныг дохионы хэлний сургалтад хамруулж багшаар бэлтгэнэ | | Дохионы хэлний сургагч багштай болж хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчилгээ үзүүлэх боломж бүрдүүлэх. | - | Дохионы хэлний сургагч багштай болж хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчилгээ үзүүлэх боломж бүрдэнэ. | | |
| 4.6.3 | Starlink буюу өндөр хурдны интернэт үйлчилгээ үзүүлэх зориулалттай хиймэл дагуулын систем нэвтрүүллээ. Гар утасны сүлжээгүй газар интернэтэд холбогдоно мөн | | Бүх ажилчин албан хаагч интернэтэд холбогдож ажил үйлчилгээг илүү түргэн шуурхай үзүүлэх боломжоор хангагдсан байна. | - | Бүх ажилчин албан хаагч интернэтэд холбогдож ажил үйлчилгээг илүү түргэн шуурхай үзүүлэх боломжоор хангагдсан байна. | Starlink интернэт нь хүний тоо болон интернэт хурд хязгаарлагдахгүй, олон хүн зэрэг хандахад гацахгүй давуу талтай. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 100mpbs-200mpbs илүү хурдтай бөгөөд олон төхөөрөмж зэрэг холбогдох боломжтой, суурин болон хөдөлгөөнт байдлаар ашиглаж болно. Үүний ач холбогдол нь Цаашид интернэтийн цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор switch төхөөрөмж starlink хүлээн авагч төхөөрөмжтэй холбож суурин компьютеруудад интернэт үйлчилгээг холбохоор төлөвлөж байна /4.6.4/ | | | | | Газрын нийт ажилчин албан хаагч интернэтэд холбогдож үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж мөн онлайн хурал, сургалтанд хамрагдах тохиолдолд интернет гацах асуудал үүсэхгүйгээр ажил үйлчилгээ үзүүлж байна. | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Эхлэх дуусса хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 6 | 7 |
| 1 | Үндэсний бичгийн танхимын сургалтанд хамрагдан, бие даан хичээллэж, үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болох; | Танхимын сургалтад 90%-иас дээш ирцтэй хамрагдсан байна.<br>-Албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болсон байна. | Үндэсний бичгийн цахим сургалтад хамрагдсан, анхан шатны түвшинтэй байна | Үндэсний бичгийн дунд шатны мэдлэгтэй бөгөөд 2025 оны 9 дүгээр сард “албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх” сургалтад хамрагдаж мэдлэгээ дээшлүүлнэ. | 2025.09.01-2025.12.31 | |
| 2 | Манлайллын ур чадварын талаарх сургалтад хамрагдах; | Удирдлагын манлайллын ур чадварын өнөөгийн түвшингээ тодорхойлж, хувь хүний манлайлах ур чадвараа ахиулах сургалтад 1-ээс доошгүй удаа хамрагдана. | - | Сургалтанд хамрагдаж эхэлсэн | 2025.06.10-2025.12.31 | |
| 3 | Компанийн засаглалын сургалтад хамрагдах; | Удирдлагын ур чадвар, эрх зүйн ойлголт, гүйцэтгэх удирдлага, хариуцлагатай ажилтан, хувь хүний талаар мэдээлэлтэй болсон байна. | - | Хугацаа болоогүй. | 2025.10.01-2025.12.31 | |
| | Байгууллагын хүний нөөцийн | Байгууллагуудын хүний | | Хугацаа болоогүй. | 2025.10.15- | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | менежментийн сургалтанд хамрагдах | нөөцийн стратегийг хөгжүүлэхэд мэргэжлийн зөвлөгөө, шинэлэг шийдэл, дэмжлэг үзүүлж, ажиллах хүчний ур чадвар, бүтээмж, урт хугацааны үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чавдартай болсон байна. | | | 2025.12.31 | |

---oOo---